

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ХӨХҮҮЛЭН ДЭМЖИХ, ХА-
РИЛЦАН ХАМГААЛАХ ТУХАЙ УКРАИНЫ ЗАС-
ГИЙН ГАЗАР, МОНГОЛЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР

Украины Засгийн газар, Монголын Засгийн газар цаашид
Хэлэлцэн тохирогч Талууд гэж нэрлэнэ,

нэг улсын хөрөнгө оруулагчаас нөгөө улсын нутаг дэвсгэрт
хөрөнгө оруулах тааламжтай нөхцөлийг бүрдүүлэх, түүний хууль
эрхийн үндэс суурийг бий болгохыг эрмэлзэж,

энэхүү хэлэлцээрийн дагуу хөрөнгө оруулалтыг хөхүүлэн
дэмжих, харилцан хамгаалах нь ажил хэрэгч санаачилгыг хөг-
жөөж, хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагааг тэгш эрх
харилцан ашигтай байх зарчмын үндсэн дээр хөгжүүлэхэд тус
дөхөм болно гэдгийг хүлээн зөвшөөрч,

доорх зүйлийг хэлэлцэн тохиров:

Нэгдүгээр зүйл

Нэр томъёо

Энэхүү хэлэлцээрт:

а/"Хөрөнгө оруулалт" гэдэгт бүх төрлийн үнэ бүхий
зүйлс, тухайлбал дараах зүйлийг багтаана. Гэвч зөвхөн эдгээ-
рээр хязгаарлагдахгүй. Үүнд:

-хөдлөх ба үл хөдлөх өмч, өмчийн зохих эрх, түүний дотор
дэнчин болон бусад зүйлс;

-пуус, үйлдвэрүүдийн хувьцаа, үнэт цаас, облигаци болон
тэдгээрт оролцох бусад хэлбэр;

-мөнгөн төлбөр болон үнэ бүхий гэрээний дагуу хүлээсэн
үүргээ биелүүлэхийг шаардах эрх;

2.

-үйлдвэрлэлийн болон окуны өмчийн эрх, түүний дотор зохиогчийн эрх, патент, барааны тэмдэг, пүүсийн нэр, үйлдвэрлэлийн дизайн, худалдааны нууц, "ноу хау", пүүсийн нэр хүнд;

-хуулиар зөвшөөрөгдсөн буюу контрактаар олгогдсон аж ахуй болон арилжааны үйл ажиллагаа явуулах эрх, тухайлбал, байгалийн баялгийг хайх, олборлох, ашиглах эрх.

Хөрөнгө оруулалтын хэлбэрийн аливаа өөрчлөлт нь "Хөрөнгө оруулалт" гэдэг тодорхойлолтыг үл хөндөнө.

б/"Орлого" гэдэгт хөрөнгө оруулалтын үр дүнд олсон өгөөж, тухайлбал ашиг, хүү, ногдол ашиг, роялти болон шан харамж орох боловч орлого нь зөвхөн эдгээрээр үл хязгаарлагдана.

в/хөрөнгө оруулагч гэж хэлэлцэн тохирогч аль аль Талын хувьд:

-Хэлэлцэн тохирогч аль нэг Талын хууль тогтоомжийн дагуу уг Талын иргэн хувь хүн;

-Хэлэлцэн тохирогч тухайн Талын хууль тогтоомжийн дагуу байгуулагдаж бүртгэгдсэн болон Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт хөрөнгө оруулах бүрэн эрх бүхий компани, фирм, хоршоо, нөхөрлөл, үйлдвэр, байгууллага, нийгэмлэг, бусад аж ахуйн нэгдлүүд.

г/"Нутаг дэвсгэр" гэж Украины хувьд олон улсын хууль эрхийн дагуу түүний бүрэн эрх болон хууль үйлчлэх газар нутаг, түүний дотор Украины нутгийн усны гадаад захтай нийлсэн тэнгисийн ёроол, хэвлийг оролцуулсан эрэг хавийн тэнгисийн район.

Монголын хувьд Монголын бүрэн эрх буюу хууль үйлчлэх нутаг дэвсгэр.

Хоёрдугаар зүйл

Хөрөнгө оруулалтыг хөхүүлэн
дэмжиж хамгаалах

Хэлэлцэн тохирогч аль нэг Тал өөрийн нутаг дэвсгэрт Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хөрөнгө оруулагчийн хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжиж, таатай нөхцөл бүрдүүлэх бөгөөд ийнхүү хөрөнгө оруулахыг өөрийн хууль тогтоомжийн дагуу зөвшөөрнө.

Хэлэлцэн тохирогч аль нэг Талын хөрөнгө оруулагчаас Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт хийсэн хөрөнгө оруулалтад ямагт шударга, эрх тэгшээр хандах бөгөөд түүнийг бүрэн хамгаалж аюулгүй байдлыг хангана.

Хэлэлцэн тохирогч аль нэг Тал өөрийн нутаг дэвсгэрт Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хөрөнгө оруулагч хөрөнгө оруулалтаа эзэмших, хэрэглэх зарцуулахад нь үндэслэлгүй буюу ялгаварлан гадуурхах арга хэмжээ авах замаар саад учруулах ёсгүй.

Хэлэлцэн тохирогч Тал тус бүр Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хөрөнгө оруулагчдын хийсэн хөрөнгө оруулалтын хувьд хүлээж авч болох аливаа үүргээ дагаж мөрдөнө.

Гуравдугаар зүйл

Хөрөнгө оруулалтын нөхцөл

Хэлэлцэн тохирогч аль нэг Талын хөрөнгө оруулагчаас Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт хийсэн хөрөнгө оруулалтад болон түүнээс олох орлогод өөрийн болон аливаа гуравдагч орны хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулалтад болон орлогод олгогдоос дутуугүй тааламжтай нөхцөл эдлүүлнэ.

Хэлэлцэн тохирогч аль аль Тал нь өөрийн нутаг дэвсгэрт Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтаа эрхлэн хөтлөх, ашиглах, хэрэглэх, зарцуулахад нь өөрийн болон аливаа гуравдагч орны хөрөнгө оруулагчдад олгодгоос дутуугүй тааламжтай нөхцөл эдлүүлнэ.

Хэлэлцэн тохирогч аль аль Талын хууль тогтоомжийн дагуу гадаадын хөрөнгө оруулагчдын хувьд хэрэглэж болох тусгай горимд дээр дурдсан үндэсний нөхцөл хамаарахгүй.

Дөрөвдүгээр зүйл

Хохирлыг нөхөн төлөх

Хэлэлцэн тохирогч аль нэг Талын хөрөнгө оруулагчаас Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэр дээр хийсэн хөрөнгө оруулалтад дайн буюу бусад зэвсэгт мөргөлдөөн, үндэсний онц байдал, бослого, үймээн, самууны улмаас хохирол учирсан байвал өмчийг сэргээн босгох, нөхөн төлөх буюу бусад хэлбэрээр зохицуулахдаа Хэлэлцэн тохирогч нөгөө Тал өөрийн орны буюу аливаа гуравдагч орны хөрөнгө оруулагчдад олгодгоос дутуугүй тааламжтай нөхцөл эдлүүлнэ. Үүний үр дүнд хийгдсэн төлбөрийг чөлөөтэй гуйвуулна.

Тавдугаар зүйл

Хөрөнгө албадан хураах

Хэлэлцэн тохирогч аль нэг Талын хөрөнгө оруулагчдаас Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт хийсэн хөрөнгө оруулалтыг тухайн Талын дотоодын зайлшгүй шаардлагаас уялдан бүх нийтийн эрх ашгийн зорилгод хамаарахаас бусад тохиолдолд улсын өмч болгох, албадан хураах буюу тэдгээртэй адилтгах арга хэмжээ /цаашид "албадан хураах" гэж нэрлэнэ/ авахгүй. Албадан хураалт нь ялгаварлан гадуурхахгүй байх зарчмын үндсэн дээр явагдах бөгөөд даруй, зохих ёсны, үр ашигтай нөхөн төлбөр хийгдэнэ.

Энэхүү нөхөн төлбөрийн хэмжээ нь хөрөнгө оруулалтыг албадан хураах тухай шийдвэрийг хэрэгжүүлэх үеийн бодит үнэтэй тохирч байх ёстой. Нөхөн төлбөрийг хойш тавилгүй хийх бөгөөд түүнийг үр ашигтай зарцуулах болон чөлөөтэй гуйвуулж болохоор гүйцэтгэнэ. Ашиг сонирхол нь хөндөгдсөн хөрөнгө оруулагч нь дээр дурдсан зарчмын дагуу өөрийн хэргийг болон хөрөнгө оруулалтын үнэлгээг хөрөнгийг хураасан Хэлэлцэн тохирогч Талын шүүхийн буюу бусад бие даасан байгууллагаар хянуулах эрхээр хангагдана.

Хэлэлцэн тохирогч аль нэг Тал нь тэнд мөрдөж буй хууль тогтоомжийнхоо дагуу байгуулагдсан бөгөөд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хөрөнгө оруулагч хувьцаа эзэмшиж байгаа компани, үйлдвэр болон аж ахуйн бусад нэгжийн эд хөрөнгийг албадан хураахдаа энэхүү хувийг эзэмшигч Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хөрөнгө оруулагчийн хувьд хөрөнгө оруулалтыг нь нэн даруй, зохих ёсоор, үр ашигтай нөхөн төлбөр хийх явдлыг баталгаажуулсан энэхүү зүйлийн заалтыг биелүүлнэ.

Зургадугаар зүйл

Хөрөнгө оруулалт, орлогыг
эгүүлэн буцаах

Хэлэлцэн тохирогч аль аль Тал Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хөрөнгө оруулагчдад өөрсдийн хөрөнгө оруулалт, орлогоо саадгүйгээр гуйвуулах баталгаа олгоно. Үүнд:

-цэвэр ашиг, ногдол ашиг, төлбөр, техникийн туслалцаа болон техникийн үйлчилгээний хөлс, хүү болон Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хөрөнгө оруулагчаас хөрөнгө оруулсны үр дүнд олсон өдөр тутмын бусад орлого;

-Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хөрөнгө оруулагчийн аливаа

хөрөнгө оруулалтыг худалдсанаас эсхүл бүхэлд нь буюу хэсэгчлэн татан буулгаснаас бий болсон ашиг;

-зээлийн төлбөрт өгөх хөрөнгө мөнгө;

-Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэр дээр хөрөнгө оруулсантай холбогцуулан тэнд ажиллаж байгаа уг Талын иргэдийн цалин;

-Хэлэлцэн тохирогч нөгөө Талын буюу гуравдагч орны нутаг дэвсгэрт оруулсан хөрөнгө оруулалтыг удирдахад зарцуулсан хөрөнгө мөнгө;

-хөрөнгө оруулалтын хэвийн ажиллагааг хангахад шаардагдах нэмэлт хөрөнгө.

Гуйвуулгыг анх хөрөнгө оруулсан валютаар буюу хөрөнгө оруулагч болон Хэлэлцэн тохирогч тухайн Талын тохиролцсон аливаа хөрвөх валютаар хойш тавилгүй гүйцэтгэгдэх бөгөөд чингэхдээ хөрөнгө оруулалт хийсэн Талын хүчин төгөлдөр үйлчилж буй валютын журмын дагуу гуйвуулга хийж буй тухайн өдрийн валютын ханшаар тооцоог хийнэ.

Дээр дурдсан гуйвуулгыг хөрвөх валютаар хийхдээ тэр валют нь хөрөнгө оруулалт болон түүний орлогоор бий болсон нөхцөлд л гуйвуулна.

Долцугаар зүйл

Тусгай заалт

Хэлэлцэн тохирогч аливаа Талын буюу гуравдагч орны хөрөнгө оруулагчдад олгогдоос дутуугүй тааламжтай нөхцөл олгох тухай энэхүү хэлэлцээрийн заалтуудыг Хэлэлцэн тохирогч аль нэг Тал дор дурдсан тохиолдолд олгосон аливаа хөнгөлөлттэй нөхцөл, хөнгөлөлт, давуутай эрхийг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хөрөнгө оруулагчдад мөн олгох үүргийг Хэлэлцэн тохирогч эхний Тал хүлээсэн мэтээр тайлбарлахгүй. Үүнд:

а/Хэлэлцэн тохирогч аль нэг Тал нь нэгдэн орсон буюу нэгдэх боломжтой одоо байгаа хийгээд цаашид бий болох гаалийн холбоо, чөлөөт худалдааны бүс, нэгдсэн тарифын бүс, валютын холбоо, хил орчмын худалдааны талаарх тохиролцоо эсхүл тэдгээртэй адилтгах олон улсын олон талт буюу хоёр талын хэлэлцээр болон эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагуудын хувьд;

б/татварын асуудалд бүхэлдээ буюу хэсэгчлэн хамаарагдах олон улсын аливаа хэлэлцээр буюу тохиролцоо эсвэл дотоодын хууль тогтоомжоор олгосон тохиолдолд.

Наймдугаар зүйл

Хөрөнгө оруулагч ба хүлээн авч байгаа Хэлэлцэн тохирогч Талын хооронд гарсан маргааныг шийдвэрлэх

Хэлэлцэн тохирогч аль нэг Талын хөрөнгө оруулагч Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хоорондын маргааныг аль болохоор эв зүйгээр шийдвэрлэнэ.

Хэрэв гомдлыг бичгээр гаргасан өдрөөс хойш 6 сарын дотор маргааныг эв зүйгээр шийдвэрлэж чадаагүй бол маргаанд оролцогч аль нэг талын хүсэлтээр ийм маргааныг авч үзэх бүрэн эрх бүхий хариуцагч орны арбитражийн шүүхэд шилжүүлэх буюу хэрэв маргаанд оролцогч аль нэг тал хүсвэл талуудын хооронд тусгай тохиролцоогоор томилогдох арбитражийн шүүхэд шилжүүлнэ.

Есдүгээр зүйл

Хэлэлцэн тохирогч Талуудын хоорондын маргааныг шийдвэрлэх

Энэхүү хэлэлцээрийг тайлбарлах, хэрэглэхтэй холбогдуулан Хэлэлцэн тохирогч Талуудын хооронд үүссэн маргааныг аль болохоор дипломат шугамаар шийдвэрлэнэ.

Хэрэв Хэлэлцэн тохирогч Талууд маргааныг ийнхүү шийдвэрлэж чадахгүй бол түүнийг Хэлэлцэн тохирогч аль нэг Талын хүсэлтээр хөндлөнгийн шүүхэд шилжүүлнэ.

Хөндлөнгийн шүүхийг тухай бүрт дор дурдсан журмаар байгуулна. Арбитрын шүүхийн тухай хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш 2 сарын дотор Хэлэлцэн тохирогч Тал тус бүр хөндлөнгийн шүүхийн нэг нэг гишүүнийг томилно. Улмаар хөндлөнгийн шүүхийн энэ хоёр гишүүн гуравдагч орны иргэнийг сонгох бөгөөд тэр нь Хэлэлцэн тохирогч хоёр Талын зөвшөөрснөөр хөндлөнгийн шүүхийн даргаар томилогдоно. Шүүхийн хоёр гишүүн томилогдсоноос хойш 2 сарын дотор шүүхийн дарга томилогдоно.

Дээр заасан хугацаанд шүүхийн зохих томилолт хийгдээгүй бөгөөд Талууд өөрөөр тохиролцоогүй бол Хэлэлцэн тохирогч аль аль Тал шаардлагатай томилолт хийхийг хүсч олон улсын шүүхийн даргад хандаж болно. Олон улсын шүүхийн дарга нь Хэлэлцэн тохирогч аль нэг Талын иргэн буюу мөн тэр нь ямар нэг шалтгаанаар энэхүү үүргийг гүйцэтгэх боломжгүй бол зохих томилолтыг хийлгүүлэхээр олон улсын шүүхийн дэд даргад санал болгоно. Хэрэв дэд дарга Хэлэлцэн тохирогч аль нэг Талын иргэн буюу дурдсан үүргийг мөн биелүүлэх боломжгүй бол Хэлэлцэн тохирогч аль нэг Талын иргэн биш олон улсын шүүхийн удаах зиндааны гишүүнд шаардлагатай томилолт хийхийг санал болгоно.

Хөндлөнгийн шүүх олонхийн саналаар шийдвэр гаргана. Энэхүү шийдвэрийг Хэлэлцэн тохирогч хоёр Тал заавал биелүүлнэ.

Хэлэлцэн тохирогч Тал тус бүр хөндлөнгийн шүүхийн бүрэлдэхүүн дэх өөрийн гишүүний болон шүүхийн ажиллагаанд өөрийгөө төлөөлүүлсний зардлыг хариуцна. Шүүхийн даргын үйл ажиллагаатай холбогдсон зардал болон бусад зардлыг Хэлэлцэн тохирогч Талууд

тэнцүү хэмжээгээр хариуцна. Гэвч шүүх нь Хэлэлцэн тохирогч аль нэг Талд зардлын ихэнх хэсгийг ногдуулахаар өөрийн шийдвэрт зааж болох бөгөөд энэхүү шийдвэрийг Хэлэлцэн тохирогч хоёр Тал заавал биелүүлэх ёстой. Шүүх нь хөндлөнгийн шүүн таслах ажиллагааны өөрийн дэгийг тогтооно.

Аравдугаар зүйл

Эрх шилжих

Хэрэв Хэлэлцэн тохирогч аль нэг Тал буюу түүний томилсон байгууллага нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт оруулсан хөрөнгө оруулалтын хувьд олгосон баталгааны дагуу төлбөр гүйцэтгэж байгаа бол даатгалын төлбөр авч буй талын бүх эрх болон нэхэмжлэх эрх хуулийн эсхүл хууль ёсны үйлдлийн дагуу Хэлэлцэн тохирогч эхний Талд буюу түүний томилсон байгууллагад шилжих, мөн эрх ийнхүү шилжсэний дагуу Хэлэлцэн тохирогч эхний Тал буюу түүний томилсон эрх бүхий байгууллага ийм эрхийг даатгалын төлбөр авсан Талын эдэлж байсан тэр хэмжээгээр эдэлж, нэхэмжлэлийг биелүүлэх болсныг Хэлэлцэн тохирогч нөгөө Тал хүлээн зөвшөөрнө.

Хэлэлцэн тохирогч тухайн Тал буюу түүний томилсон байгууллага нь шилжүүлэн авсан эрх болон нэхэмжлэл хийх эрхийн хувьд мөн түүнчлэн эдгээр эрх, нэхэмжлэх эрхийг хэрэгжүүлсний үр дүнд авсан аливаа төлбөрийн хувьд даатгалын төлбөр авсан Тал энэхүү хэлэлцээрийн үндсэн дээр тодорхой хөрөнгө оруулалт болон түүнээс гарсан орлогын хувьд эдэлж байсан нөхцөлийг аль ч тохиолдолд нэгэн адил эдэлнэ.

Хэлэлцэн тохирогч тухайн Тал буюу түүний томилсон байгууллага шилжүүлэн авсан эрх болон нэхэмжлэх эрхээ хэрэгжүүлсний үр дүнд үл хөрвөх валютаар олж авсан аливаа төлбөрийг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэр дээр гарсан зарцлаа нөхөхөд чөлөөтэй ашиглана.

10.

Арван нэгдүгээр зүйл
Хэлэлцээрийг хэрэглэх

Энэхүү Хэлэлцээр нь түүний хүчин төгөлдөр болсноос хойно оруулсан бүх хөрөнгө оруулалтад хамаарна.

Арван хоёрдугаар зүйл
Бусад дүрэм журмыг хэрэглэх

Хэрэв энэхүү хэлэлцээрээс гадна Хэлэлцэн тохирогч аль нэг Талын хууль болон олон улсын эрх зүйн буюу Хэлэлцэн тохирогч Талуудын хооронд харилцан хүлээсэн хүчин төгөлдөр үүргүүд нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулалтад энэхүү Хэлэлцээрт дурдсанаас илүү тааламжтай нөхцөл олгож байгаа нийтлэг болон тусгай заалттай бол эдгээр заалтыг энэхүү хэлэлцээрээс илүү ашигтай нөхцөл тогтоосон хэсэгт нь дагаж мөрдөнө.

Арван гуравдугаар зүйл
Хэлэлцээр хүчин төгөлдөр болох

Энэхүү хэлэлцээр нь түүнд гарын үсэг зурсан өдрөөс хүчин төгөлдөр болно.

Арван дөрөвдүгээр зүйл
Хэлэлцээрийн үйлчлэх хугацаа, түүнийг дуусгавар болгох

Энэхүү хэлэлцээр 10 жилийн хугацаанд хүчинтэй байна. Цаашид энэхүү хэлэлцээр нь Хэлэлцэн тохирогч аль нэг Тал Хэлэлцэн тохирогч нөгөө Талдаа түүнийг дуусгавар болгох тухайгаа 12 сарын өмнө бичгээр мэдэгдээгүй бол хэлэлцээр цаашид ч хүчин төгөлдөр хэвээр байх бөгөөд энэхүү хэлэлцээрийг хүчин

II.

төгөлдөр байх үед оруулсан хөрөнгө оруулалтын хувьд, түүний хэлэлцээр хүчингүй болсноос хойш 10 жилийн хугацаанд мөрдөгдөх бөгөөд түүнээс цаашхи хугацаанд олон улсын эрх зүйн нийтлэг хэм хэмжээг мөрдөх явдлыг үгүйсгэхгүй болно.

Дээр дурдсаныг нотлон тус тусын Засгийн газраас зохих ёсоор эрх олгосноор дор дурдсан хүмүүс энэхүү хэлэлцээрт гарын үсэг зурав.

Хэлэлцээрийг Улаанбаатар хотноо 1992 оны II дүгээр сарын 5-ны өдөр тус бүр украин, монгол хэлээр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх хувиуд нь адил хүчинтэй байна.

УКРАИНЫ ЗАСГИЙН ГАЗРЫН
ӨМНӨӨС



МОНГОЛЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ӨМНӨӨС

